

ТУХН БА ОРОСЫН ГЕОПОЛИТИКИЙН ЗАРИМ ТӨСӨӨЛӨЛ

*Д.Баярхүү**

Оршил болгож ТУХН-ийн эв нэгдлийн төлөө тууштай тэмцдэг Белорусийн Ерөнхийлөгч Александр Лукашенкогийн нэгэн үгийг эшлэвэл: Эрчим хүчний нөөцийн төлөө, цэргээ байлгахын төлөө, эрх мэдлийн төлөө дүрэмгүй глобал дайн хуучин СССР-ийн нутаг дэвсгэр дээр явагдаж байна. Хуучин Зөвлөлт Холбоот Улсын өргөн уудам энэ орон зай нэгдмэл нэг орон зай шиг оршиж эгнэгт чадахгүй болжээ. Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөл (ТУХН)-ийг нураах оролдлого гаднаас ч, дотроос ч хүчтэй өрнөж байна. ТУХН-ийн улсууд хэдэн биенийхээ эсрэг улс төрийн баррикад босгожээ¹ гэжээ.

2006 оноор ТУХН булшлагдлаа гэсэн дүгнэлтэй та бид таарч болох юм.² Ийм дүгнэлт хаа нэгтэй улс төрчдөөс, зарим судлаачдаас цухалзаж, ТУХН-ийн гишүүн улсуудын “тусгаарлах нь ихсэж, нөхөрлөх нь багасч” байгаа тухай таагүй мэдээ улам олшрох төлөвтэй. ТУХН-д цаашид байх ач холбогдол бараг алга хэмээн зарим нэг гишүүн улс нь мэдэгдэж, ТУХН-өөс гарах асуудлыг авч үзэхийг илээр шаардах болжээ. ТУХН-ийн зарим гишүүн орнууд салах санаархлаа мэдрүүлж, Ющенко, Саакашвили, Алиев, Воронин нар “ГУАМ” (Гүрж, Украин, Азербайжан, Молдова) хэмээх нээлтэй, бүс нутгийн олон улсын эвсэл байгуулан, ардчилал, тогтвортой байдал, аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх зорилгоо 2006 онд зарлажээ. Энэ үзэгдлийг оросын нэрт политолог Владимир Горюнов (Улс төрийн эксперт, зөвлөхүүдийн Холбооны зөвлөлийн гишүүн) тайлбарлаж “Постсоветское отступление России” сэдвээр 2005 оны эхээр ярилцага өгөхдөө ОХУ геополитикийн бүх фронт дээр ялагдал хүлээж байна гэж хүлээн зөвшөөрчээ.³

Ардчилагдаагүйн гай нүүрлэсэн хүчин зүйл

Эдүгээ ТУХН-д нүүрлээд буй салж бутрах оролдлого гэнэтийн зүйл огтоос биш. Улс төр, эдийн засгийн хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан буй. Эн тэргүүнд өрнийнхний ардчиллын үнэт зүйлс ТУХН-ийн бүс нутагт байнга нэвтрэн орсоны шууд нөлөө байв. Учир нь анхнаасаа ардчилсан бус, коммунист тогтолцоотой тоталитари ганц гүрнээс салбарласан

* Д.Баярхүү - Дипломатч, олон улсын харилцааны судлаач, профессор

Энд бичсэн судалгааны өгүүлэл бол түүний ГХЯ-нд эрхэлдэг ажилтай нь огт хамааралгүй бөгөөд ГХЯ-ны албан ёсны байр суурь биш гэдгийг уншигчид болгооно уу.

субъектууд ТУХН-ийг байгуулснаас үүдэн ардчиллын эхний хүчтэйхэн давалгаанаар сүйрч унасан нь 2005 оны үйл явдлууд нотлов.

Үйл явцыг ажваас ТУХН-ийг тараах эхний алхмууд хэд хэдэн үе шаттай явагдаж байна. Үүнд:

1) Ардчилсан хөдөлгөөнийг төрийн эргэлтгүй хослуулан засгийн эрх авдаг сонин практик ТУХН-ийн орнуудад хэвших төлөвтэй.

2) Тэгснээ ТУХН-ийн цөм болох – Оростой харилцаагаа ёс мэт муутган хэсэг бужигнуулснаа буулт хийлгэх тактик сонгож байна.

3) Энэ алхмууд нь өрнийнхний дэмжлэг хүлээн, дэлхий дахины анхаарлын төвд орж, олон улсын нэр хүнд нь дээшилж, Оросын эсрэг аль нэг эвслийг бараадах алхам руу түлхэж байна.

4) Энэ бүхний эцэст Оросоор геополитикийн буулт хийлгэн, түүхэн ужиграсан асуудлаа шийдүүлэх тактик сонгоно.

Үүнийн анхдагч биет жишээ – Михаил Саакашвили гарч ирүүтээ Москваг шууд өлөн дуудаж, Гүржэд хэзээ ч харьяагдаж байгаагүй Ажарыг Гүржэд нэгтгэсэн ба Өмнөд Осетийг мөн тийм замаар оруулах гэж байна. Умард Осетинтэй нэгдэж, тэгснээрээ ОХУ-ын бүрэлдэхүүнд нэгдэх гэсэн тэдний өнө мөнхийн хүсэл нь ийнхүү талаар болох, эсвэл мөнхийн мөргөлдөөний бай, сэдэв болж үлдэхээс өөр сонголт байхгүй мэт.

Украинд Ерөнхийлөгч Виктор Ющенко нь Москвагийн гадаад бодлого зүг чигээ алдсаны гайгаар гараад ирсэн мэт Москвад одоо үзсэн хэвээр байгаа нь геополитикийн харалган дүгнэлт юм. Гүрж, Украин хоёул Москваг геополитикийн шахаанд зэрэг оруулж, Гүрж дэх Ажар, Абхазын мөргөлдөөнийг олон улсын энхийг сахиулах хүчний оролцоотой шийдэхээр шахаж, ингэснээр Гүрж дэх “Оросын цэнхэр дуулгатан” украиныхаар солигдох хэтийн төлөв ажиглагдав. Үүндээ Гүрж АНУ болон НАТО-гийнхны дэмжлэгт багтай найдаж, Кавказ дахь Оросын геополитикийн цайз Гүржээр тас татуулах эхлэл нэгэнтээ бүрджээ.

Оросууд “оранжево-розовая” антироссийская дуга гэж нэрлээд буй энэ тэнхлэг Орост их гай тарих магадлалтай юм. Украин, Гүрж дэх Оросын ялагдлын гай улс төр, эдийн засгийн хэр их уршигтайг одоо тооцоолоход бэрх. Хамгийн гол гай бол Орост сэтгэхүйн маш том нөлөө үлдээчихээд байна. Украин бол түүхнээсээ Оросын үнэнхүү уугуул газар нутаг, тэгээд ч нэлээдгүй хэсэгт нь нутгийн уугуул оросууд суурьшиж буй, энэ бүхнийг “Проект Ющенко” гэгч нь нурааж хаяжээ хэмээн улс төр судлаач Владимир Горюнов халаглан бичжээ.⁴

Баруун хойд этгээдэд Калининград муж, Оросын хууль ёсны нутаг байж ирсэн, гэтэл 2005 оноос Оросын иргэд тийшээ иргэний үнэмлэх бус,

гадаад паспортоор зорчих болж байна. Наашлаад Латвид гэхэд л орос хэл дээр сургууль хичээллэж болохоо больж, энэ маргаан Брюссель хүрч зарга үүсгэсэн ч Оросын ялагдлаар дуусчээ. 2005 оны хавар Москвад дуулиантай тэмдэглэсэн Ялалтын 60 жилийн ойн баярт Балтийн гурван улсын төрийн тэргүүнүүд очихгүй гэдгээ зэрэг зарлаж, нацистуудын үйлдсэнтэй адил нүглийг зөвлөлтүүд үйлдсэн гэж илээр сурталчилж байв. Энэ нь ч мөн Орост учирч буй, ирээдүйд учирсаар байх геосэтгэхүйн дарамт мөн.

“ГУАМ” (Гүрж, Украин, Азербайжан, Молдова) хэмээх нэгэн шинэ эвсэл Оросыг тойрч байгуулагдсан нь Оросын эсрэг мөн чанарыг улам мэдрүүлье гэсэн Украин, Гүржийн санал бөгөөд ГУАМ-ыг “*Ардчилал, хөгжлийн төлөө байгууллага*” (АХТБ) хэмээн нэрлэе гэсэн санал ч нэлээд дэмжигдэх бололтой. ТУХН-ийг булшлах лут алхмыг 2005 оны сүүлчээр хэсэг улс хийсэн ба тэр үед байгуулагдсан Сообщество демократического выбора (СДВ) буюу Ардчилсан сонголтын хамтын нийгэмлэг (АСХН) гэх эвсэлд ТУХН-ийн гурван гишүүн – Гүрж, Молдова, Украин орж, тэдэнтэй Польш, Латви, Литва, Эстони, Македони, Румын, Словени эвсчээ. Энэ алхамдаа эрэмшсэн гурав нь ГУАМ-ыг гаргаж ирсэн түүх ийм байна.

Эдийн засгийн хүчин зүйл

Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн гишүүд эдийн засгийн талаар бие даан хөгжих чадалтай болсоны нотолгоо нь ТУХН тарах явдал хэмээн тараагчид нь нотлож байна. ТУХН байгуулагдсаны дараахи эхний үед гишүүн орнууд нь хуучин СССР-ийн үеэс уламжлагдсан эдийн засгийн дарамтанд үлэмж байсан ба эдийн засгаар хүчирхэг, байгалийн нөөц баялгаар хахсан ОХУ нь бусад орнууддаа эдийн засгийн тусламж үзүүлэх, адаглаад зах зээлийн шилжилтийн хямралыг гэтлэн давах халхавч нь болж байлаа. Оросын эдийн засагт ТУХН-ийн гишүүн бусад орнууд ийн түшиглэж, тэр нь Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл гэгчийг нэгтгэн зангидах гол баталгаа болж байсан хэрэг. Гэтэл сүүд рүүгээ бусад орнуудынх нь эдийн засаг аажмаар сэргэж, зах зээлийн эдийн засагт шилжин, тэгснээрээ Оросын эдийн засгийг түших нь багасаж, ТУХН цаад гол ач холбогдлоо алдаж эхэлсэн байна.

“ГУАМ” (Гүрж, Украин, Азербайжан, Молдова) хэмээх шинэ эвслийн тухайд, уг нь ГУУАМ буюу Узбекистан оролцсон 5 улсын холбоо маягтай үүсээд 2005 оны хавар Узбекистанд өрнөсөн ардчиллын хөдөлгөөн, түүнийг цус урсган дарсан хэрэг явдлын дараа энэ улсын олон улсын нэр хүнд унаж, Орос руу хандахаас аргагүй байдалд хүрчээ. Одоо “ГУАМ” нь ТУХН-ийг шууд сөрсөн, газар зүйг улс төртэй холбосон геополитикийн

тэнхлэг маягаар (Прибалтика - Украин - Молдова – Гүрж) сууриа тавьж байна. Өөрөөр хэлбэл Европ руу чиглэсэн Оросын эрчим хүчний бодлого, түүний дамжин өнгөрөх хонгилыг бүсэлсэн шинжийг агуулжээ.

Оросын нефть, хийн хоолойг боймилбол Оросыг Европын улс гэж нэрлэхэд нэн түвэгтэй болно. Оросын нефть, хийн тээвэрлэлтийг (нийлүүлэлт) орлох альтернатив асуудлыг шийдчихвэл ГУАМ-ын зорилго биеллээ гэсэн үг. Энэ бол Молдовын Ерөнхийлөгч В.Воронины хэлсэн үг. Оросоос хамаарахгүй байя гэдгийг Азербайжан аль хэдийнэ санаачлаад Каспийн тэнгисээс нефть хийн хангалт хийх боломжит бүх сувгийг эрэлхийлж байна. Цаадуул нь ч Баку-Жейханы хоолойг тэсэн ядан хүлээж суугаа. Энэ төсөл Түркээс болж бага зэрэг галсан боловч хаашдаа нээгдэнэ. ГУАМ-ийг тэтгэгч нь Иран байх бас хувилбар бий. Үүнийг Иран санаачилсан ч одоогоор АНУ гацаагаад байгаа. Тэгээд ч Оросоос байгалийн хий 110 ам.доллараар авч байгаагаа Иранаас 230 ам.доллараар авна гэсэн үг болох тул ГУАМ-ын дунд хугацааны зорилт гээд хойшлуулжээ.

ГУАМ-ын эдийн засгийн интеграци ямараар төсөөлөгдөж байна вэ? Энэ тухай бишгүй бичиж ярьж байгаа боловч Оросгүй интеграци бас л үлгэр болох тавилантай. “Евразийн эдийн засгийн орон зай” (ЕЭП)⁶ гэгчийг үүний альтернатив хувилбар гэж нөгөө талаас үзэж байна. Энэ бол Украин, Гүрж хоёр яалт ч үгүй Орос, Казахстан, Беларусьтай хамтран ажиллах нэг ёсны тулгалт юм. Украины хувьд энэ бол нээлттэй, удтал хөндөгдөх сэдэв. Харин Гүржийн хувьд Украин, Азербайжан хоёртой нягт хоршвол Оросгүй байж болно. ТУХН-ийн дотор Молдов-Гүрж хоёр хоёр талын харилцааны механизмгүй өнөө хүрсэн тул Молдов-Гүржийн харилцаа энд гогцоо асуудал биш. Хэрэв ГУАМ-ыг “Ардчилал, хөгжлийн төлөө байгууллага” (АХТБ) гэж нэрлэлээ гэхэд ГУАМ эргээд тарж бутрах бас нэг хувилбар байна. Тэдэнд Оросын нефть, байгалийн хий нэгдүгээрт чухлаар тавигдан буй, ардчилал бол хойгуур яригдах учиртай хэмээн зарим нь сөргөж байна. Оросууд байгалийн хийн үнэ тарифаа буулгачихвал ГУАМ-ын оршин байх утга бас саармагжих талтай. Молдова, Азербайжаны дотоодын хуваагдмал байдал, Нагорно-Карабах, “Днестрийн БНУ” тойрсон геополитик нь ГУАМ-ын энхийг сахиулах чиглэлийг тодорхойлох магадлалтай.

Молдовын Ерөнхийлөгч В.Воронины үзэж байгаагаар, АХТБ – ГУАМ-ын гишүүнээр эл 4 улсаас гадна Европын Холбооны зарим гишүүд, Европын Холбооны ойрын ирээдүйн гишүүн болох Болгар, Румын байх ёстой аж. Үүнийгээ нөгөөх эрчим хүчний хонгил гэдгээр тайлбарлажээ.

ГУАМ ч төрдгөө төрлөө. Цаанаасаа ч дэмжлэгтэй нь харагдаж байна. Сөргүүлэх институци ТУХН-д юу үлдэв. Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕврАзЭС), гишүүн нь Орос, Беларусь, Казахстан, Киргиз, Тажикистан, Узбекистан гэх 6 улсын эвсэл байна. Энд Армен, Молдова, Украин нь ажиглагч статустай. Тэгснээ Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага (ОДКБ) буюу Орос, Беларусь, Армен, Казахстан, Киргиз, Тажикистан, Узбекистан багтдаг цэрэг-улс төрийн НАТО-гийн эвсэлэрхүү юм байна. ТУХН хэдэн хэсэгт тарж бутраад байгааг илтгэх энэ хэдхэн жишээг дурдахад л, ТУХН гэгч манай их хөрш маань геополитикийн тоглоомын ая даасангүй боллотой.

“Белградын сценари” буюу “Орос-Беларусийн Холбоо”

Хашилтанд авсан энэ үгийг тайлахад хялбар. Хамгийн их найрсаг байх ёстой, найрсаг гэж ч харагдаж байсан Беларусь Орост, Орос нь Беларусьгаа туйлын тааламжгүй байдлаар ханддаг болж байна. “Славяны гурван эгч дүүс” байгсадыг “Тбилисс-Киевийн” хувилбараар нэг бужигнуулаад, үлдэх ганц хувилбар нь “Белградын сценари” л байх болно гэж судлаач Владимир Горюнов үзэж байна.⁶ Тэр нь Югославын задрал шиг үзэгдэл Оросыг тойрч дэгдэх магадлал ажээ. Лукашенкогийн дэглэмийг өрнийн түншүүд нь ардчилсан хувьсгалаар бус, эдийн засгийн хатуу цээрлэл – эдийн засгийн бүслэлтээр нурааж, болохгүй бол хүч хэрэглэх нь бараг хамгийн үнэн бодит магадлал байж болно. Беларусийг Оросын оролцоогүй эдийн засгийн бүслэлтээр сөхрүүлэх нь зарчмын хувьд мэдээж бүтэшгүй, гэвч үүнийг өрнийнхөн мэдэхгүй биш мэдэж байгаа. Оросын гадаад бодлогын үхэнц байдал үүнийг зөвтгөх биз ээ. Тиймдээ ч “блокад”-ын хувилбар аль хэдийнэ бэлэн болжээ хэмээн Горюнов цааш нь бичжээ.⁷

Төв Азид мөн Орос геополитикийн ялагдлын босгон дээр байна. Тажик-Афганы хилээс Оросын хилчид гэдрэг татагдаж, тэр улс тогтворгүй байгаа зэргээс ийм дүгнэлт хийж болно. Ойрын хэдэн жилдээ Тажикистан лав тогтвортой болохгүй, Молдова, Армен, Азербайжан, Киргиз, магадгүй Казахстанд байдал хэцүүдэхийг Владимир Горюнов үгүйсгэхгүй байна. Радикал исламистууд Оросын өмнөд муж, бүс нутгуудад Кавказ, Төв Азиас нөлөөгөө тэлэхийг оролдох нь гарцаагүй. Кремлийнхэн Украинд баларсны дараа нь энэ асуудал бараг шийдэгдсэн. Ер нь Орос яагаад геополитикийн бүх чиглэлд ингэж бүтэлгүйтээд байна вэ?

Хуучин Зөвлөлтийн орон зай дээр Орос ийнхүү алхам тутамдаа ялагдаж байгаа нь ТУХН дэх ойрын хөршүүддээ геополитикийн ямар ч төсөл төлөвлөгөө өнөө хүртэл санал болгоогүй, улиг болсон өмнөх

төсөөллөөрөө хандаж ирсэн, харин ТУХН-ийн орнуудын хожмын залуу үе Москвагийн өмнө ямар нэг эрсдэл, эсвэл ах дүүсэг ёсыг хүсэхгүй өнгөрөх төлөвтэй.

Чухамдаа Орос орон ямар гадаад бодлого явуулахыг өрнийн түншүүд, өмнөдийн лалын дайснууд нь Орост өөрт нь мэдрүүлсээр ирсэн ч Москвад түүнийг хэрэгсээгүй. Цаадуул нь “хүйтэн дайны” үеийн тогтоомын дүрмээ аль хэдийнэ гээсэн, ялангуяа түнш ба өрсөлдөгчийн сонирхол нөлөөний хүрээг хөндөхгүй гэсэн дүрэм байхгүй болсон, гэтэл Орос яг тэр дүрмээр гадагш харж байна. Нэгэнт олон улсын харилцаанд тоглоомын дүрэмгүй, бүтэлгүйтэж яваа Оросын хувьд хоёр сонголт л байна. Үүнд:

1) СССР-ийн орон зайд бие даасан гадаад бодлого явуулж, дэлхийн бүх хүчний төвүүдийн өмнө эрх ашгаа тулштай хамгаалах, эсвэл бүр татгалзах, хэрэв татгалзаж байгаа бол дэлхийн бүх хүчний төвүүдтэй ягштал тохиролцох;

2) “Хязгаарлагдмал бүрэн эрх” гэгч номлолоор явж ОХУ өөрөө дэлхийн бодлогын бие даасан субъект байхаа зогсоох явдал гэнэ.

Энэ хоёр сонголтын алин нь ч маш хэцүү, гэвч СССР нурсны дараа орос биш улс түмнүүдийн алин нь ч Оросын эсрэг, эсвэл Оросын нөлөөн дор сонголт хийгээгүй, харин үүнийг Украины сонголт нэг тийш болгож өгөх шиг. Украинчууд ч шийдэж өгсөн юм биш, оросууд өөрсдөө тэднийг шийдүүлсэн. Украинд барууны тал баримтлагч төр барьж байгаа нь Москвагийнхан ойрын хөршүүддээ геополитикийн ямар ч төсөлгүй өнөөг хүргэсний гор, улиг домог болсон өмнөх ойлголтоороо хандаж ирсний үр дүн гэж Москвад үзэх явдал түгээмэл байна. Цаашдаа ТУХН-ийн орнуудад орос хэлтэн сонгогч хэд хичнээн, ямар жин татах, өрнийнхнийг дагасан хэнийг ч болов гаргаж болохгүй гэсэн үхширсэн бодлогоосоо Кремлийнхэн ичиж зоволтгүй татгалзах хэрэгтэй болсон хэмээн Горюнов “Постсоветское отступление России” өгүүлэлдээ хатуу анхааруулжээ.

2005 оны Украины улбар шар хувьсгалын дараа Орос-Өрнийнхний харилцаа муудсан. Гэхдээ тэгтлээ дордсон нь үгүй. Эхлээд жад зөрүүлж уулзаад дараа нь буулт эрэлхийлэх нь гарцаагүй. Оросын хувьд бүрэн эрхт байдал, вассаль улсын хооронд сонголт л үлдэж байна. Энэ гашуун бодит үнэнийг тойрч гарах ёсгүй гэж Владимир Горюнов эцэст нь дүгнэн бичжээ.

Геополитикийн бүрхүүлгүй Орос

Манай умард хөрш Орос нь түүх-газар зүй, угсаа гарал, соёл, шашин иргэншлийн хувьд Европ, Азид нэгэн зэрэг хамаарах хоёрдмол

харьяалал бүхий улс болох тухай их сэтгэгчид – Н.Трубешкой, В.Вернадский, П.Савицкий, химич Д.Менделеев, түүхч Л.Гумилев нар үе дамжуулан бичиж номлосон байдагсан. Дэлхийд Орос шиг газар зүйн ийм хоршсон харьяалалтай улс төдийлөн (Туркээс өөр үгүй) байхгүй ба хэрэв Аляска нь Хаант Оросын мэдлийн хэвээрээ үлдсэнсэн бол бүр гурав дахь харьяаллын асуудал ч бахархалтайяа бичигдэх байлаа.⁸

Гэтэл яагаад ингэсэнгүй вэ? Геополитикийн буруу сонголт, түүний балаг гэж эдүгээ өөрсдөө ил тод шүүмжлэн ярьж байна. Ямар балгийн тухайд тэр вэ? Эхлээд дараахи хүснэгт⁹ нэгийг хэлээд өгөх байх.

1. Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн: Гурав дахь ертөнцийн социалист чиг баримжаат, капиталист бус хөгжлийн замаар замнагч хөгжиж буй орнууд. Мөн капиталист орнууд дахь Зөвлөлтийн “5 дугаар дувааны” коммунист-ажилчны намууд буюу Олон улсын коммунист хөдөлгөөн
2. Социалист систем, социалист хамтын нөхөрлөл - ЭЗХТЗ, ВГБ эвсэл буюу Оросын эзэнт гүрний геополитикийн гол холбоотон (энд БНМАУ)
3. СССР-ийн орос биш үндэстний холбооны 14 БНУ (СССР задарснаар нутаг дэвсгэрийнхээ 24 хувийг алдаж, хүн ам нь 44 хувиар хорогдсон)
4. РСФСР дэх орос биш үндэстний АССР, тойрог, муж – Одоогийн ОХУ

Энэ хүснэгт дээрхи эхний гурав нь нэгэнтээ арилж Орос орон геополитикийн гурван гол халхавчаа алдчихаад байгааг гол том балаг гэж хэлж байна. Геополитикийн бүрхүүлгүй Орос одоо нүцгэрэн үлджээ.

Хэрэв геополитикийн буруу сонголт хийвэл тайван цагт ч улс гүрэн доройтон сүйрч болдгийн сонгодог жишээ нь хүснэгт дээрхи Орос өөрөө юм. Хэдийгээр “хүйтэн дайн” байлдааны талбарт бус, энхийн бүтээн байгуулалтын уралдаанаар, хүчний тэнцвэр, үзэл суртлын талбарт өрнөж байсан ч энэ нь нэгдмэл СССР-ийг шууд нураагаагүй юм. Харин энэ гүрний удирдагчид, энэ гүрнийг залж чиглүүлсэн ЗХУКН улс төр, үзэл суртлын амбицдаа хэт хөтлөгдөн, цэргийн аванторын зам сонгон авч, эдийн засаг, байгалийн баялаг, хүний нөөц, моралийг бүхэлд нь хөлдөө чирсэн хэмээн эдүгээ ОХУ-д эрүүл саруулаар дүгнэж байна.

Геополитикийн хэт буруу алдаатай чиглэлээр, сөргөлдөх зам сонгон авч өөртөө балаг тарьсан тухайд В.Жириновскийн зэмлэн буруушаасныг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. СССР-ийн үед Куба, Вьетнам, Афганистан, мөн Африкийн олон арван оронд тусалж байсны хариу өнөөдөр юу үлдэв ээ? Би тэнд алагдсан ба сураггүй болсон, эрэмдэг үлдсэн орос цэргүүдийн тухай ярьж буй хэрэг биш, геополитикийн ямар хожил авчрав гэдэг дээр ярьж байна хэмээн В.Жириновский эрх баригчиддаа ноцтой асуулга тавьсаар байна.

Орос шиг ингэж буруу сонголт хийсний харгайгаар гэх үү, түүхэн жам ёсоороо гэх үү дэлхийн геополитикийн тавцнаас сүүлийн 100-500 жилийн дотор дэлхийн ихэнхи их гүрнүүд арчигдан алга болсны эхнийх нь Монголын нэгдсэн эзэнт гүрэн ба сүүлчийнх нь XX зууны СССР болж байна.¹⁰ Энд арчигдах гэдгийг ул мөргүй алга болсон гэдгээр хэлсэнгүй, их гүрний статусаа алдаж, их гүрэн байхаа больжээ гэсэн үг. Энд би Итали, Испани, Португал, Нидерланд, Австри, Турк, Бельги, Швед, Иран гэхчлэн эдүгээ оршин буй улсуудыг нэрлэж байна. Эдгээрээс гадна түүхээс нэр нь арчигдаж архивт орсон олон арван улс үндэстэн бараг бүх тив дээр бий.

СССР-ээс ОХУ юу өвлөн авсан бэ гэдэг маргаантай адармаатай асуудлыг одоогоор тайлж тайлбарлахад нэн түвэгтэй. Гэхдээ олон улсын харилцааны өнөөгийн системд өөрийгөө тодорхойлж болох хангалттай хүч нөөц, хүчин зүйлсийг СССР өвлүүлэн үлдээсэн атал энэ орны эдийн засаг, хүн ам зүй, экологийн бэрхшээл ямагт нэмэгдэж, нутаг дэвсгэр, угсаатны зөрчил хурцалсаар байна.

Ерөөсөө Оросын геополитикийн ялагдлыг дараахи гурван үндэслэлээр оросууд өөрсдөө тайлбарлаж байна. Ялангуяа энэ талаар дагнан судалгаа хийдэг философич Александр Дугины бичсэнээс эшлэбэл:

1. Юуны өмнө ОХУ нь геополитикийн нэн таагүй нөхцөлд байгаа гэж үзэх явдал. Энэ бол “түүхэн таагүй нөхцөл” гэсэн үг огт биш, харин СССР-ийн үед эргэн тойрондоо тийм таагүй орчныг бүрдүүлээд орхисонд байгаа гэнэ. Эдийн засгийн бэрхшээлийн уг сурвалжийг эндээс гаргаж тооцож байна. ОХУ нь хоёр тивийг дамнан, гурван их далайгаар хүрээлэгдэн, эргэн тойрондоо харьцуулшгүй эрс тэс, өмнөө улс үндэстнүүдээр хүрээлэгдсэн ба баруун зүүн, өмнөгүй дандаа сулхан хөршүүдтэй үлдсэн ажээ. Сулхан гэдэг нь зам тээврийн зэрэг дэд бүтцийн хөгжилгүй, Орост өөрт нь гарлагатай гэсэн үг.

2. Газар зүйн байршил нь хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөний зөрчлийг яах аргагүй дагуулж байна. 150 сая гаруй хүн ам бүхий Орос оронд 100 гаруй этнос (үндэстэн угсаатан) аж төрж байгаагаас орос голдуу соёлжсон хэсэг нь Европын хэсэгтээ, орос бус үндэстнүүд нь хил хязгаар, бөглүүд нутаг, эсвэл хөгжлөөр дорой районд суурьшсан. Хүн амын дунд төрөлт харилцан адилгүй, лалын шашинт үндэстний цөөнхийн район, Кавказын хавьд төрөлт нэн өндөр. Эр, эм хүйсийн ялгаа, дүрвэгсэд, цагаачлал, гэмт хэрэг гэхэд төрийн хяналт алдагдсан.

3. ОХУ-ын Холбооны улсын бүтцийн байгуулалт нь өөрөө зөрчлийн эх сурвалж, холбооны субъектуудын хоорондын хил нь

маргааны сэдэв болж ирсэн. Үндэстнүүдийн бие даах эрх нь эдийн засаг, цэргийн ашиг сонирхолд захирагдаж ирсэний уршгаар угсаатны ба орон нутгийн мөргөлдөөн нөхцөлдсөн. Одоогийн тооцоогоор, хэрэв дээрхи зөрчлийг зөв шийдэж чадахгүй бол дор хаяж үндэстний 30 жижиг улс салж гарах аюул нүүрлэнэ. Өнөөгийн ОХУ-д СССР-ээс өвлөж авсан 7 сая ам дөрвөлжин км нутаг дэвсгэр маргаантайд тооцогдож байна. Энд олон үндэстний 30 гаруй сая хүн оршин суугаа. Улсын хилийг тогтоохдоо түүхэн хилийн шугамыг хүчээр, волонтарист замаар муйхар хандсаны балаг гарч байна¹¹ гэжээ.

Энд олон тайлбар хэрэггүй. Зөвтөл юмуу, буруутгал бас хэрэггүй, ерөөсөө гал дээр тос нэмэлтгүй. Манай умард хөрш, “ах дүүгийн найрамдлын” тодотголтой, 100 хувь шатахуунаар хамаарсан тэр орны судлаачид улс орныхоо үнэн бодит байдлыг дүгнэн бичиж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Лукашенко сравнил жизнь в СНГ с боями без правил, [lenta.ru /news/8.2006.08.01](http://lenta.ru/news/8.2006.08.01)
2. Оросын www.lenta.ru; www.inosmi.ru вэб сайтын 2006 оны мэдээллээс түүвэрлэн авч тайлбарлав
3. Владимир Горюнов. “Постсоветское отступление России”, “Росбалт”, Январь 2005
4. Мөн тэнд
5. ЕврАзЭС гэсэн товчлолоор ихэнхдээ явдаг.
6. Владимир Горюнов. “Постсоветское отступление России”, “Росбалт”, Январь 2005
7. Мөн тэнд
8. Энэ тухай зохиогчийн “Евразийн геополитик, олон улсын харилцаа: Өнгөрсөн, одоо, ирээдүй, (Нэмж завсарласан 3 дахь хэвлэл) МУИС, ОУХС, ШУА-ийн ОУСХ, 2005” номоос дэлгэрүүлж үзнэ үү.
9. А.Дугин. Основы геополитики, М., 1997
10. Монголчуудын ид ааглан явсан XIII зуунаас тэдний тарж нурсан XV зуунаар нэг түүхэн мөчлөг гэж үзээд тэр үеэс XX зууны сүүлч хүртэл 500 жил.
11. А.Дугин. Основы геополитики, М., 1997